



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 4/85

Мандалговь

Тандалтын багийг томилох тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 дахь заалт, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны “Журам шинэчилэн батлах тухай” 28 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2016 оны “Заавар батлах тухай” А/291, 2018 оны “Халдварт өвчний тохиолдлыг тандах журам батлах тухай” А/527, 2022 оны “Журам, заавар батлах тухай” А/373 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хам шинж болон лабораторийн тандалтыг эрчимжүүлж, улаанбурханы сэжигтэй тохиолдлыг илрүүлэх, мэдээлэх, халдвартын тохиолдолд тандалт судалгааг шуурхай зохион байгуулж халдвартын тархалтын эрсдлийг хязгаарлах арга хэмжээг авч, удирдлагуудыг шуурхай мэдээллээр хангаж ажиллах “Улаанбурхан өвчний эрт сээрэмжлүүлэх тандалт судалгааны баг”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, мэдээллийн урсгалын зураглалыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Халдварт өвчний хам шинж сэжигтэй тохиолдол болон томуугийн харуулдан тандалтыг эрчимжүүлэн зохион байгуулж, шаардлагатай урвалж оношлуурын нөөцийг бүрдүүлж лабораторийн тандалтад сорьц тээвэрлэлтийг эрчимжүүлж, тандалтын мэдээг тухай бүр хугацаанд нь мэдээлж ажиллахыг эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн дарга наарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалыг хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга (Б.Саруулцэцэг)-д даалгасугай.

ДАРГА: *Д.М/* БАЛТАНТӨГС



Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн
A/85 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ТАНДАЛТЫН
БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ахлагч: Б.Саруулцэцэг (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн
дарга)

Гишүүд:

Н.Цогзолмаа (Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн сургалт хариуцсан
мэргэжилтэн, тархвар судлагч)

Б.Ширчмаа (Эрүүл мэндийн газрын Орчны эрүүл мэнд, хоол тэжээлийн
асуудал хариуцсан мэргэжилтэн)


Ё.Цэцэг-Өлзий (Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн мэдээ, мэдээллийн
цахим сан хариуцсан мэргэжилтэн)

Б.Бямбасүрэн (Нэгдсэн эмнэлгийн Халдвартын сэргийлэлт, хяналтын албаны
дарга, тархвар судлагч)


Б.Уранцэцэг (Нэгдсэн эмнэлгийн Лабораторийн тасгийн эрхлэгч)

Нарийн бичиг: Д.Цэрэнчунт (Эрүүл мэндийн газрын Халдварт бус өвчний асуудал
хариуцсан мэргэжилтэн, тархвар судлагч)

**УЛААНБУРХАН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛЫГ
МЭДЭЭЛЭХ УРСГАЛЫН ЗУРАГТАЛ**



**УЛДАНБУРХАН ХАЛДВАРТ ӨВЧНИЙ СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛЫГ
МЭДЭЭЛЭХ УРСГАЛЫН ЗУРАГЛАЛ**



Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн
A/85 дугаар тушааны 2 дугаар хавсралт

9034064 4810120119